



ДУЛААН ШИЙДЭЛ
SWITCH OFF AIR POLLUTION



ДУЛААН ШИЙДЭЛ ТӨСӨЛ

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

"Дулаан шийдэл" төсөл нь 2018 оноос хойш Улаанбаатар хотын гэр хорооллын хувийн сууцыг дулаалж, дулаан алдагдлыг багасгаснаар агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулах зорилготой үйл ажиллагаа явуулж байна. Төслийн санхүүжүүлэгч байгууллагаар Европын холбооны Свитч-Эшиа хөтөлбөр, Абби Пиер сан, Чехийн хөгжлийн агентлаг болон Францийн хөгжлийн агентлаг ажиллаж байна. Төслийг Жэрэс ОУТББ, ШУТИС-ын дэргэдэх Барилгын эрчим хүч хэмнэлтийн төв, Монголын барилгын үндэсний ассоциаци ТББ болон Пипл ин Нийд ОУТББ хамтран хэрэгжүүлж байна.

Зорилтот бүс

- Улаанбаатар хотын гэр хороолол

Хэрэгжих хугацаа:

- 2018 - 2022.04 сар

Зорилт:

- 1000 өрхийг дулаалах
- 3000 тонн хүлэмжийн хийг бууруулах
- 800 тонн түлш хэрэглэхээс сэргийлэх

САНХҮҮЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

switchasia
GRANTS PROGRAMME



Funded by the
European Union



FONDATION
Abbé Pierre



CZECH REPUBLIC
DEVELOPMENT COOPERATION



AFD

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

"БИД ДУЛААЛГААС ИЛҮҮ"

Улаанбаатар хотын гэр хороололд дулаан алдагдал багатай байшин барихад дэмжлэг үзүүлж, зөвлөгөө өгөх, санхүүгийн зуучлалын үйлчилгээ үзүүлэхийг зорино.

Гэр хорооллын айл өрхүүдийн нүүрсхүчлийн хий болон нарийн ширхэгт тоосонцорын хэмжээг бууруулснаар оршин суугчдын зан үйл, хандлагад нөлөөлж түлшний хэрэглээг бууруулна.

Дулаалгын салбарт үйл ажиллагаа явуулж буй Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд (БЖДБ) мэргэжил, арга зүйн хувьд дэмжлэг үзүүлнэ.

ЗОРИЛТОТ БҮЛГҮҮД



Гэр хороололд амьдарч буй иргэд



Барилгын салбарын БЖДБ эрхлэгчид



Орон нутгийн захиргаа



Санхүүгийн байгууллагууд



Барилгын материал нийлүүлэгчид



Олон улсын хөгжлийн агентлагууд

СУУРЬ СУДАЛГАА

Айл өрхийн дулаан алдагдал, агаарын бохирдлын тухай мэдлэг хандлагыг ойлгох зорилготой **Суурь судалгааны тайланг** боловсруулав. Уг судалгаагаар дамжуулан айл өрхүүдийн санхүүгийн нөхцөл байдал, чадамж, цаашдын хэрэгцээг тодорхойлов.

Улаанбаатар хотын гэр хороололд амьдарч буй байшин сууцтай айл өрхүүдийн **Нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал, хадгаламжтай болох байдлыг судлах**, ойлгох зорилго бүхий Судалгааг хийж гүйцэтгэв.

Гэр хорооллын хувийн сууцын ангилал, халаалтын эх үүсвэрийн тухай судалгаагаар орон сууцны хэв маяг, барихдаа гаргадаг нийтлэг алдааг тогтоож, тухайн байшингуудын дулаан алдагдлын эх үүсвэрүүдийг тодорхойлов.

Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн хэмжээнд барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй БЖДБ эрхлэгчид, бригадуудын мэдээллийн санг бүрдүүлэх судалгаагаар тэдний ажлын туршлага, мэргэжлийн чадавх, эдийн засгийн үзүүлэлт, ажиллах хүчний мэдээллийг бүрдүүлэв.

ДУЛААН ШИЙДЭЛ ТӨСӨЛ



Бүтэн дулаалгын өмнө



Бүтэн дулаалгын дараа

ТӨСЛИЙН ОЛОЛТ, АМЖИЛТ



Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ-д барилгын салбарт ажиллаж буй БЖБД бизнес эрхлэгчдийг ногоон ажлын байранд зуучлах, сургаж, дадлагажуулах зорилгоор **Салбар** байгуулав.



Дулаалгын зах зээлийн загварыг бий болгов. Гэр хороололд амьдарч буй айл өрхүүдийн хэрэгцээнд үндэслэн, чанарын шаардлага хангасан материалаар дулаалгын ажлыг өндөр түвшинд хийж гүйцэтгэж байна.



Дулаалгын талаар мэдээлэл түгээх төслийн вэбсайт www.dulaalga.mn бий болов. Мөн "Дулаан шийдэл төсөл" Фэйсбүүк хуудас болон, **+976-75052000 Дуудлага төвөөр** төслийн гол сурталчилгааны ажил явагдаж байна.



KPI



Ажил гүйцэтгэлийн үнэлгээг нэвтрүүлж бригадын ажлын чанарт хяналт тавьж байна.




CRFM

Олон нийтийн санал гомдлын механизм баримт бичиг шинээр гарч, санал гомдлыг шийдвэрлэх хороо байгуулагдав.

БЖБД эрхлэгчдэд зориулсан сургалтын хөтөлбөрүүд боловсруулагдав:

- Онол, практик
- Эрчим хүчний зөвлөх
- Бизнесийн
- Жендер хамгааллын
- Вэбсайт
- Маркетинг, борлуулалт



БҮТЭЭГДЭХҮҮН



Дээврийн дулаалга: 5 см, 10см, 15см, 20см



Ханын дулаалга: Эрдэс хөвөн, EPS хөөсөнцөр



Цонх суурилуулалт



Суурийн дулаалга: XPS хөөсөнцөр



Бүтэн болон хэсэгчилсэн дулаалга



Хаан банк, Хас банк, Транскапитал ББСБ-аар **ногоон зээл** олгож байна.

Жил бүр **Өвлийн хэмжилтийг** бүтэн болон хагас дулаалга хийлгэсэн, мөн дулаалаагүй айлуудад хийж дотор агаарын чанар, дулааны тав тух, түлшний хэрэглээ зэргийг хэмжиж байна. Мөн эрчим хүчний хэмнэлт үзүүлэх **Шилэн гонхыг** туршилтаар хийж байна.

ХЯЛБАР ШИЙДЭЛ

Хялбар, хямд арга ашиглан гарын доорх материалаар байшингаа дулаалах "Хялбар шийдэл" аян зохион байгуулагдав. Аяны хүрээнд хөршийн холбоонд суурилан иргэдэд хүрч ажилласан бөгөөд дулаалгын ач холбогдол, тав тухыг олон нийтэд таниулахаас гадна өрх бүр өөрөө хэрэгжүүлж болох дулаалгын аргуудыг зааж өгөв.



1,050

Хялбар шийдлийг хэрэгжүүлсэн айл өрх



175

Цонх, хаалганы багцыг түгээв

267

278 айлын дээврийг 5см-ийн эрдэс хөвөнгөөр дулааллаа



13,300

Фэйсбүүк группын гишүүдийн тоо

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

